Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Хоол үйлдвэрлэлийн хэлтэс

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Хүүхдийн хоолны шим тэжээл, чанар хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох | Улсын төсөв 135 сая | Бодлогын баримт бичгийн тоо | 4 | 5 | | 1. ЕБСХҮҮ-ний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал батлагдсан. ХХуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд сургуулийн хоол хүнсний хангамжид чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүний тогтвортой ханган нийүүлэхэд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тодорхой болгох, нэг хүүхдийн хоолны үйлчилгээний бүрэн өртгийг тооцон (хувьсах зардлаар) санхүүжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангах, хяналт үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан. 2. Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх боломж, шийдлийн талаарх | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судалгааг 2023, 2024 онуудад хийсэн бөгөөд үдийн хоолны үйлчилгээг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэхэд нэг суралцагчийн үдийн хоолны түүхий эдийн 2500 төгрөг +1691 төгрөг гэж тооцон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, "Хүүхдийн хоол" хэлэлцүүлэгт оролцогчдод танилцуулж, хэлэлцүүлсэн. 3.Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар Засгийн газрын 2020 оны 207 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр”-т туссан арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг баталсан. Удирдамжид заасны дагуу 21 аймаг, нийслэлээс ЗГ-ын 2020 оны 207 дугаар тогтоол, ЗГ-ын 2021 оны 18-р тогтоолд заасан арга хэмжээг шалгуур үзүүлэлт, статистик тоо мэдээлэл, санхүүгийн дүнд өөрсдийн үнэлгээг хийлгүүлэн авч, нягтлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэсэн. | | |
| 1.1.3 | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг өртөгт шилжүүлэн тооцох Засгийн газрын тогтоол боловсруулж, | - | Засгийн газрын тогтоолын төсөл | Судалгаа | Судалгаа тооцоол хийх | Засгийн газрын тогтоол батлуулна. | Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх боломж, шийдлийн талаарх судалгааг 2023, 2024 онуудад хийсэн бөгөөд үдийн хоолны үйлчилгээг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэхэд нэг суралцагчийн үдийн хоолны түүхий эдийн 2500 төгрөг +1691 төгрөг гэж тооцон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан "Хүүхдийн хоол" хэлэлцүүлэгт хоолны түүхий эдийн зардлыг өртөгт суурилсан тогтолцоонд шилжүүлэх талаар танилцуулж, хэлэлцүүллээ. Одоогоор хүчин | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцүүлнэ. | | | | | | төгөлдөр мөрдөгдөж буй хувьсах зардлаас хоолзүйч, тогоочийн цалин хөлсийг, орон нутгаас урсгал зардлыг /цахилгаан, ус/ санхүүжүүлж байгаа нь 1691 төгрөгийн 1124 төгрөгийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 567 төгрөг нь хоолзүйч, тогоочийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын зардал, хөдөлмөр хагаалаллын зардал, тоног төхөөрөмжийг засвар, үйлчилгээний зардалд, нөхөн хангалтын зардал байх юм. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалд санхүүжилтийн шинэчлэлийг хийх асуудлыг тусган батлуулж, хуулийн төслийг боловсруулах ажил хийгдэж байна. Хавсралт: 5 файл | | |
| 1.1.4 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | 135.00 | Хуулийн төсөл | Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын төслийн судалгаа | Хуулийн төслийн судалгаа хийж, үзэл баримтлалын төсөл батлуулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна. | Хуулийн төсөл боловсруулсан байна. | 1. ЕБСХҮҮ-ний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалыг Боловсролын сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд хамтран баталсан. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд сургуулийн хоол хүнсний хангамжид чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүний тогтвортой ханган нийүүлэхэд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тодорхой болгох, нэг хүүхдийн хоолны үйлчилгээний бүрэн өртгийг тооцон (хувьсах зардлаар) санхүүжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангах, хяналт үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан. 2.Хуулийн төслийг боловсруулахад салбар хоорондын уялдаа холбоог хангах үүрэг бүхий ажлын хэсгийг | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боловсролын сайдын 2025 оны А/126 дугаар баталж, шаардагдах зардал болох 70,000,000 төгрөгийг Боловсролын сайдын 2025 оны А/155 дугаар тушаалаар баталсан. Хуулийн төсөл, төслийн танилцуулга болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох бусад судалгаа, тайлан, баримт бичгийн төслийг боловсруулах БЯ/20250201044 дугаартай зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулж, "Гурхайдай" ХХК-тай 68,000,000 төгрөгийн ХҮХ-2025/164 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. 3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол хүнсний үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хоол шим тэжээлийн боловсрол олгох, хууль эрх зүйн орчны шинэчлэл, санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд талуудын оролцоо, санал шийдлийг гаргах зорилгоор "Хүүхдийн хоол" хэлэлцүүлгийг 2025.5.20-ны өдөр Чингис хаан Үндэсний музейд зохион байгуулав. Тус арга хэмжээнд УИХ-ын гишүүн, ЕТГ, ТЗТБ болон ЕБС-ын тогооч, хоолзүйч нарын нийт 75 төлөөлөл оролцсон. 4. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалыг танилцуулан, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, санал солилцох уулзалтыг 2025.6.6-ны өдөр цахим болон танхимаар зохион байгуулав. Уулзалтад ЕБС-ын удирдлага, хоол зүйч, тогооч нарын нийт 60 төлөөлөл оролцсон.<br>Хавсралт: 8 файл | | |
| 1.1.5 | Сургуулийн хоол үйлдвэрлэл, | - | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын 2020 оны 207, 2021 | Засгийн газрын 2020 оны 207, 2021 | Засгийн газрын хуралдаанд | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар Засгийн газрын 2020 оны 207 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий | 100% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг дэмжсэн төлөвлөгөө өг батлуулна | | | оны 18 дугаар тогтоол | оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийнэ | хэлэлцүүлнэ | боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр"-т туссан арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг баталсан. Удирдамжид заасны дагуу 21 аймаг, нийслэлээс ЗГ-ын 2020 оны 207 дугаар тогтоол, ЗГ-ын 2021 оны 18-р тогтоолд заасан арга хэмжээг шалгуур үзүүлэлт, статистик тоо мэдээлэл, санхүүгийн дүнд өөрсдийн үнэлгээг хийлгүүлэн авч, нягтлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэсэн. Урьдчилсан байдлаар "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг 10 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд ерөнхий хэрэгжилт 83 хувьтай байна. Мөн "Хоол зүйч" албан тушаалыг төрийн албан тушаалын зэрэглэлд шинээр нэвтрүүлж, орон нутгийн нэмэгдлийг олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь салбарын бодлогын хувьд томоохон ахиц гарсан байна.<br>Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон шалгуур үзүүлэлтийн биелэлт, зарцуулсан санхүүжилт зэрэгт үндэслэн үе шатын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Засгийн газрын 18 дугаар тогтоолын хэрэгжилтэд БЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт үнэлгээг зохион байгуулж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.2. | Шим тэжээлийн хэмжээг хангахуйц, тэгш хүртээмжт | 18,500.00 | 1. "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрт хамрагдсан суралцагчи | 1-т 5 хувь, 2-т 1 арга хэмжээ | 1-т 7,1 хувь, 2-т 5 доошгүй арга хэмжээ | | 1. Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх тухай хуулийн төсөлд а. Хуулийн төслийн 8.1-т "... хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан ...," гэснийг "... хангах боломжтой тохирлын баталгаатай | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эй хоол, хүнсний үйлчилгээг нэвтрүүлэх | | йн эзлэх хувь 2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд орчинд дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | | | чанар, стандартын шаардлага хангасан ..," гэж өөрчлөх; б. Төслийн 8.4-т шинээр "8.4.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол хүнсний хангамжид тухайн бүс орон нутагт үйлдвэрлэсэн тохирлын баталгаатай, чанар стандартын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх" гэж нэмэх; в. Хуулийн төслийн 36.1.16-т "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол, хүнсний хангамжийг худалдан авах ажиллагаа 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд" гэж шинээр тусгах; г. Тендерт оролцогчийн гаргасан гомдол үндэслэлгүй, тогтоогдоогүй бол эргээд гомдол гаргасан оролцогчийн тендерийн баталгааг улсын орлого болгохоос гадна тендерт оролцох эрхийг хасаж эрхээ хязгаарлуулсан этгээдийн хар жагсаалтад оруулах санал хүргүүслэн. 2.Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийн хүрээнд 2024 онд сүү хөтөлбөр хэрэгжүүлсэн аймаг, орон нутгийн тайлан судалгааг гаргав. 2024 онд Улаанбаатар, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий аймгийн нийт 227 цэцэрлэг, сургуулийн 81,964 суралцагч орон нутгийн төсөв болон эцэг, эх, асран хамгаалагч, төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 120-250 мл хэмжээтэй сүүг 7 хоногийн 1-5 өдөр нэмэлтээр өгсөн байна. 2025 онд "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийг нийслэл болон 12 аймаг /Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Хэнтий, Баянхонгор, Дорнод, Дархан-Уул/-ийн 241 цэцэрлэг, сургуулийн 85,262 суралцагч хамрагдаж байна. 3.Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн хүрээнд "Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хоололтод | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжлэг үзүүлэх аргачлалыг боловсруулан, цэцэрлэг, сургуульд зориулан хэвлүүлсэн. Уг гарын авлагад орсон агуулга бүрээр видео хичээл боловсруулж, MEDLE.MN-д байршуулсан. | | |
| 1.2.1 | Цэцэрлэг сургуулийн хүнсний хангамжид орон нутгийн хүнсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, худалдан авалтыг оновчтой зохион байгуулалтын сүлжээ бий болгох | - | Хоолны түүхий эдийг цахим дэлгүүрээс худалдан авдаг цэцэрлэг, сургуулийн эзлэх хувь | 10 хувь | 15 хувь | 30 хувь | 1. МУ-ын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх тухай хуулийн төсөлд дараах саналыг боловсруулан СХОГ-т хүргүүлэв. Үүнд: а. Хуулийн төслийн 8.1-т “... хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан ...,” гэснийг “... хангах боломжтой тохирлын баталгаатай чанар, стандартын шаардлага хангасан ..,” гэж өөрчлөх; б. Төслийн 8.4-т шинээр “8.4.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол хүнсний хангамжид тухайн бүс орон нутагт үйлдвэрлэсэн тохирлын баталгаатай, чанар стандартын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх” гэж нэмэх; в. Хуулийн төслийн 36.1.16-т “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол, хүнсний хангамжийг худалдан авах ажиллагаа 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд” гэж шинээр тусгах; г. Тендерт оролцогчийн гаргасан гомдол үндэслэлгүй, тогтоогдоогүй бол эргээд гомдол гаргасан оролцогчийн тендерийн баталгааг улсын орлого болгохоос гадна тендерт оролцох эрхийг хасаж эрхээ хязгаарлуулсан этгээдийн хар жагсаалтад оруулах / 2. Цахим дэлгүүрээс 15 аж ахуйн нэгжийн 40 нэр төрлийн нэр төрлийн 89 багц хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 2 их сургууль, 11 цэцэрлэг, 55 ерөнхий боловсролын сургууль нийт 2,901,299,809.0 төгрөгийн үнэ бүхий 460774 ширхэг бүтээгдэхүүн худалдан авалт | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийсэн байна. Худалдан авалтын дүнд 163,874,791 төгрөгийн хэмнэлтийг төсөвт бий болгосон байна. 3. Орон нутагт нийт 7 аймагт сургуулийн хоолны нэгдсэн цэсийг хэрэгжүүлэн ажилласан, түүнчлэн Ерөнхий гэрээгээг худалдан авах үйл ажиллагааг өргөжүүлэн Дархан- Уул, Орхон, Увс аймгуудад зохион байгуулж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.2.2 | Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх Засгийн газрын тогоол боловсруулж, хэлэлцүүлэх | 18,500.00 орон нутгийн төсөв | дунд хугацааны төлөвлөгөө | Засгийн газрын тогтоол/дунд хугацааны төлөвлөгөө/ | Засгийн газрын тогтоолын төсөл | Засгийн газрын тогтоол | 1. "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийн хүрээнд 2024 онд сүү хөтөлбөр хэрэгжүүлсэн аймаг, орон нутгийн тайлан судалгааг гаргав. 2024 онд Улаанбаатар, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий аймгийн нийт 227 цэцэрлэг, сургуулийн 81,964 суралцагч орон нутгийн төсөв болон эцэг, эх, асран хамгаалагч, төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 120-250 мл хэмжээтэй сүүг 7 хоногийн 1-5 өдөр нэмэлтээр өгсөн байна. 2025 онд "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийг нийслэл болон 12 аймаг /Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Хэнтий, Баянхонгор, Дорнод, Дархан-Уул/-ийн 241 цэцэрлэг, сургуулийн 85,262 суралцагч хамрагдаж байна. 2. Хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын оролцоог хангах зорилгоор Боловсролын сайдын А/93 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулав. Тус ажлын хэсэгт ЕТГ, ЭЗХЯ, ЭМЯ, ХХААХҮЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-иын ХХААБ болон холбогдох төлөөлөл орсон. Тус ажлын хэсгийн анхны хурлыг 4 сард зохион байгуулсан бөгөөд хурлаар Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлж буй олон улсын туршлага, Монгол улсын хөтөлбөрийн хэрэгжилт, | 100% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өнөөгийн байдал, МУ-ын сүүний хангамжийн өнөөгийн нөхцөл байдал зэрэг салбар дундын мэдээлэл солилцож, гишүүдэд хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг танилцуулж, санал солилцов. 3. Боловсролын сайдын "Арга хэмжээ зохион байгуулах, зардал батлах тухай" 2025 оны А/246 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч нарт Монголын 5 өнгийн идээ ундааг ашиглан түүх соёл, өв уламжлал, ёс заншлыг таниулах "Уламжлалт сүү, цагаан идээ боловсруулах өдөрлөг"-ийг Лосолын лааган хүүхдийн хөгжил НҮТББ-тай хамтран 2025.05.30-ны өдөр зохион байгуулав. 4. Дэлхийн сүүний өдөрт зориулан, сургууль цэцэрлэгийн хүүхдийг сүүгээр хангах боломж хэлэлцүүлэгт оролцсон.<br>Хавсралт: 8 файл | | |
| 1.2.3 | Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан тохируулгат арга хэмжээг хэрэгжүүлнэ | - | Аргачлалын дагуу үнэлж, туршсан байна | Үнэлгээний аргачлал, хоолны жор технологи | Зорилтод 45 сургууль /тусгай2 цэцэрлэг/-д хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийг үнэлж, туршилт эхэлсэн байна. | Зорилтод 45 сургуульд үнэлгээний аргачлал, хоолны цэсийг хэрэгжүүлсэн байна. | 1. Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт суралцагчдад зориулсан хооллох хэрэглэгдэхүүний судалгааг нийслэлийн ЕБ-ын тусгай 25, 55, 63, 70-р сургуулиудаас авч удирдлагад танилцуулан "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-д хүргүүлэв. 2. Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2-р бүрэлдэхүүний хүрээнд "Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хооллолтод дэмжлэг үзүүлэх аргачлалыг боловсруулан, цэцэрлэг, сургуульд зориулан хэвлүүлсэн. Уг гарын авлагад орсон бэрхшээлийн онцлог ялгаа, гарын авлагыг хэрхэн ашиглах, хэн хэн ямар үүрэгтэй оролцох талаар 13 теле хичээл бэлтгэн MEDLE.MN-ний теле хичээл-Эрүүл мэнд, зөв хооллолт буланд байршуулж, түүнийг гарын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авлагад QR код болгон байршуулснаар эцэг эх асран хамгаалагч, багш ажилчид ашиглахад хялбар болгосон. https://www.medle.mn/telelesson/99/500/100004931963858/99 Хавсралт: 2 файл | | |
| 1.3. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, нэгдсэн удирлагаар хангах | - | Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хийсэн арга хэмжээний тоо | 1 | 2 | | 1. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд цахим хяналтын системийг улсын хэмжээнд 309 цэцэрлэг, ерөнхий боловсролын 69 сургууль нэвтрүүлсэн байна. Энэ нь нийт цэцэрлэг, сургуулийн 40 хувийг эзэлж байна. 2. Хоолзүйчийн мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт болон тогоочийн ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан. 3. Тогоочид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан. | 70% | 70 % |
| 1.3.1 | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд цахим хяналтын системийг цэцэрлэг, сургуульд нэвтрүүлнэ | - | цахим систем ашиглаж буй цэцэрлэг, сургуулийн эзлэх хувь | 18 хувь | 50 хувь | 70 хувь | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд цахим хяналтын системийг улсын хэмжээнд 309 цэцэрлэг, ерөнхий боловсролын 69 сургууль нэвтрүүлсэн байна. Энэ нь нийт цэцэрлэг, сургуулийн 40 хувийг эзэлж байна. Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыгн тодорхой хэсгийг эцэг эх, асран хамгаалагчаас санхүүжүүлж байгаатай холбоотойгоор нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэг 100 хувь цахим системд шилжиж хүүхдэд өдрөөр хоолны түүхий эдийн зардлыг санхүүжүүлж байна. Эцэг эх, асран хамгаалагчаас төвлөрүүлэх орлого 85,4%-тай байна. Хоолны цахим системийг 2025 оны 9 дүгээр сарын 1-нээс өдрөөс үндэсний хэмжээнд нэтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 1.3.3 | Хоолзүйч, тогоочийн тасралтгүй хөгжлийг хангах давтан сургалтын журам боловсруулах | - | Сайдын тушаал/журмын төсөл | - | Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт боловсруулах | Давтан сургах журам | Хоолзүйчийн мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт болон тогоочийн ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан. Хоолзүйчийн мэргэшлийн зэргийн шалгуур үзүүлэлтийн багш бус ажилчдын шалгууртай ойролцоо байхаар боловсруулсан болович, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтад заасан цэцэрлэг, сургуулийн багш, зарим ажилчдын мэргэжлийн нэршилд ороогүй тул тусгайлан батлах боломжгүй байна. тиймээс ГБХНХЯаманд Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлэхээр бэлтгэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалын төсөлд хоол үйлдвэрлэлийн ажилчдын тасралтгүй хөгжлийг хангах, давтан сургах бодлогыг хэрэгжүүлэх заалтыг тусган батлуулсан.<br>Хавсралт: 2 файл | 50% | 50 % |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 4.1. | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэри | - | - | - | - | | Хууль, тогтоол шийдвэрийн биелэлт, ЗГҮАХАХТ, Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг 25 баримт бичгийн 38 арга хэмжээний биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан. Мөн Кайка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх" төслийн зорилтод сургууль болох 40,48,9-р сургууль, Чадавх бэхжүүлэх төвийн засвар үйлчилгээний гүйцэтгэгч шалгаруулах арга хэмжээнд мэдээ, мэдээлэл, баримт бичиг, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | йн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | | | | | | зураг төсвийг хүргүүлэн, шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах бүх арга хэмжээг авч ажиллалаа. | | |
| 4.1.1 | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг | үйл ажиллагааны зардлаар | Биелэлтийн хувь | 2024 оны гүйцэтгэлийн түвшин | 100 хувь | 100 хувь | Хууль, тогтоол шийдвэрийн биелэлт, ЗГҮАХАХТ, Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг 25 баримт бичгийн 38 арга хэмжээний биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан. Мөн Кайка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх" төслийн зорилтод сургууль болох 40,48,9-р сургууль, Чадавх бэхжүүлэх төвийн засвар үйлчилгээний гүйцэтгэгч шалгаруулах арга хэмжээнд мэдээ, мэдээлэл, баримт бичиг, зураг төсвийг хүргүүлэн, шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах бүх арга хэмжээг авч ажиллалаа. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлагнах | | | | | | Хавсралт: 5 файл | | |
| 4.1.2 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн тоо | 2024 оны гүйцэтгэлийн түвшин | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2-р бүрэлдэхүүний хүрээнд "Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хооллолтод дэмжлэг үзүүлэх аргачлалыг боловсруулан, цэцэрлэг, сургуульд зориулан хэвлүүлсэн. Уг гарын авлагад орсон бэрхшээлийн онцлог ялгаа, гарын авлагыг хэрхэн ашиглах, хэн хэн ямар үүрэгтэй оролцох талаар 13 теле хичээл бэлтгэн MEDLE.MN-ний теле хичээл-Эрүүл мэнд, зөв хооллолт буланд байршуулж, түүнийг гарын авлагад QR код болгон байршуулснаар эцэг эх асран хамгаалагч, багш ажилчид ашиглахад хялбар болгосон. https://www.medle.mn/telelesson/99/500/10000 4931963858/99 Хүүхдийн хоол хэлэлцүүлэгийн хүрээнд "Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хоололтын байдал" болон "Өсвөр насны хүүхдийн хооллолтын байдал" штарк хийж, яамны пэйж хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр түгээсэн. Хавсралт: 4 файл | 100% | 100 % |

*Үнэлсэн:* .........................

*.........................................* *.........................* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

*..........................................* *.........................* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*